

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2019 ОНЫ 08 ДУГААР САРЫН МЭДЭЭ

2019.08.23

**АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫН ТАЛААР:**

Аймаг байгуулагдсаны 25 жилийн ой, Боржигин-2019 наадмын үеэр “Цэвэрхэн наадацгаая” аяны уриалга болон иргэдийг зөв боловсон бие засах хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх санамж бичгийг нийтийн бие засах газрууд болон наадамчин олон ихээр цугларах газрууд, үйлдвэрлэл үйлчилгээ явуулж буй 200 гаруй цэгт байршуулсан.

Тус ажлын хүрээнд иргэдийн хандлага сайжран зөв боловсон бие засч хүрээлэн буй орчинд учруулах бохирдлын хэмжээ өмнөх жилүүдийн баяр наадмын өдрүүдтэй харьцуулахад буурсан байсан.



Мөн баяр наадмын өдрүүдэд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайд Н. Цэрэнбатын санаачлан хэрэгжүүлж буй “Хандлагаа өөрчилье” багц ажлын “Цэвэрхэн наадацгаая” арга хэмжээний хүрээнд “Нэг уут хог, Нэг сугалаа” арга хэмжээ зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд наадамчин олон идэвхтэй оролцож 338 гаруй сугалаа сугалуулж, 12 тонн хог хаягдлыг хогийн цэгт төвлөрүүлсэн. Энэ ажлын хүрээнд

иргэдийн хандлага сайжирч байгальд хаясан хогний хэмжээ багасан цэвэрхэн сайхан наадацгаасан.



“Цэвэрхэн наадацгаа” аяны тайланг 2019 оны 08 дугаар сарын 09-ны өдөр 200 дугаартай албан бичгээр Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн.

#### **АН АМЬТНЫ ТАЛААР:**

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2019 онд Арабын Нэгдсэн Эмират, Катар улсын зарим иргэд, зочдод соёлын зориулалтаар хэд хэдэн аймагт идлэг шонхор барих тусгай зөвшөөрөл олгосны дагуу уг ажлыг Баянтал сумын нутаг дэвсгэрт зохион байгуулагдхаар бэлтгэл ажил хангаж буйтай холбогдуулан байгаль орчны, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар 2019 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 199 дүгээр албан бичгээр Баянтал сумын Засаг дарга Д.Мөнх-Эрдэнэд чиглэл хүргүүлэн хамтран ажиллаж байна.

Мөн сумын ЗДТГ-ын төрийн сангийн ан агнуур нөөцийн төлбөрийн дансанд 74 000 000 төгрөг төвлөрүүлээд байна.

## УС, УСНЫ НӨӨЦ АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН ТАЛААР:

Ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар хайгуул хийж “Цэргийн алдарын хөшөө” болон “Мод үржүүлгийн газар”-т худаг гаргуулахаар “МОНКАРОТАЖ” ХХК –тай гэрээ байгуулан ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.



Хянасан: БОАЖГ-ын дарга

Д.Мөнх-Эрдэнэ

Мэдээ гаргасан: Мэргэжилтэн

С.Сувдмаа